 2. Өвчтөнөөс анамнез авах /ухаантай байвал/
 3. Гүйдлийн тэмдэг илрүүлэх үзлэг хийх
 4. Зүрх судас болон амьсгалын тогтолцоо ТМС-ын байдалд үнэлгээ өгөх
 5. Ажлын нөхцөл
- /136./ Шаант чөмөгний хугарлын үед хүндрэл гарах шалтгаан онцлог
1. Цусан хангамж муутай
 2. Шаантны урд хэсэг арьсан доорхи өөхлөг эд байхгүй
 3. Цус лимфийн зогсингшил үүсэх нь амар
 4. Биеийн ачаалал төвлөрдөг
 5. Хөдөлгөөн ихтэй
- /137./ Нугас дарагдсан гол шинжүүд юу вэ?
1. Хөлөө өргөж чадахгүй байх
 2. Тодорхой түвшингээс доош мэдээгүйжих

3. Нуруугаар хүчтэй өвдөж хэлбэр дүрс алдагдах
4. Аарцгийн эрхтэнүүдийн үйл ажиллагаа алдагдах
5. Хоёр хөл рүү хүчтэй өвдөх

/138./ Алганы завь хэлбэрийн ясны дутмагшлыг нөхөхөд хаанаас яс авах нь тохиромжтой вэ?

1. Дунд чөмөгнөөс
2. Өвчүүнээс
3. Тахилзуураас
4. Шуунаас
5. Шилбэнээс

/139./ Гарал үүслээр хэвлийн наалдацыг яаж ангилах вэ?

1. Төрөлхийн
2. Аяндаа үүссэн /спонтанный/
3. Хагалгааны дараах
4. Гэмтлийн
5. Үрэвслээс

/140./ Цементээр бэхэлсэн, түнхний суулгацын хөл нь ямар хүчтэй нөлөөнд илүүтэй суларч ганхах вэ?

1. Түнхний үеэр мушгирч үрцэлдэх
2. Арагшаа мушгирч эргэх
3. Хэт ачаалалтай явснаас
4. Тэнхлэг дагуу ачаалалтай явснаас
5. Хажуу тийш нугалах

/141./ Тулгуур хөдөлгөөний эрхтэний хагалгааны туйлийн эсрэг заалт аль нь вэ?

1. Өвчтөний биеийн байдал маш хүнд
2. Халдвар өвчнөөр өвдөөд удаагүй
3. Хагалгаа хийх хэсгийн арьс идээт үрэвсэлтэй
4. Өндөр настай
5. Зүрх судасны дутмагшилтай

/142./ Ясны ил болон битүү хугарлын үндсэн хүндрэлүүд

1. зөв биш бороололт
2. бороолоогүй
3. хуурамч үе
4. Гэмтлийн шалтгаант остеомиелит
5. Бороололт удаашрах

/143./ Түлэгдсэний дараах эхний өдөрт арьс улайсан байвал түлэгдлийн ямар зэрэгт орох вэ?

1. II-Б
2. II-А
3. I-Б
4. I
5. II

/144./ Түлэнхийн өвчний хүнд хөнгөнийг аль үзүүлэлт нь харуулах вэ?

1. Түлэнхийн талбай
2. Бөөрний ялгаруулах үйл ажиллагаа
3. Түлэнхийн зэрэг
4. Зүрх судасны үйл ажиллагаа
5. Ухаан санаа самуурах

/145./ Нүүр, хүзүүнд арьс нөхөхөд тохиромжтой “донорын” хэсэг

1. Чихний ар
2. Эгэмний доод хэсэг
3. Эгэмний дээд хэсэг
4. Цавины хэсэг
5. Шилбэний хэсэг

/146./ Антибиотик эмчилгээг түлэнхийн цусан халдварын үед ямар журмаар хэрэглэх вэ?

1. Антибиотикыг венийн судсанд тарих
 2. Антибиотик эмчилгээг антибиотик мэдрэг болон цусны ариун чанарын хяналтан доор хийнэ.
 3. Антибиотикыг хавсруулан хэрэглэнэ.
 4. Өндөр тунгаар пенициллинийг эхлээд хэрэглэнэ.
 5. 4-6 долоо хоногоос илүүгүйгээр эмчилгээг хийнэ.
- /147./ Атгаалын дээд булууны хугарлын ангилал
1. анатомийн хүзүүний хугарал
 2. мэс заслын хүзүүний хугарал
 3. товгорууд дайрсан хугарал
 4. хумсан сэртэнгийн хугарал
 5. жинс хүзүүний хугарал
- /148./ Тархины доргилтын үед бодит үзлэгээр илрэх шинж тэмдэгүүдийг заана уу
1. Нүдний алимны чичирхийлэх хөдөлгөөн илрэнэ
 2. Арьс шөрмөсний рефлексүүд буурах буюу ихсэх
 3. Артерийн даралт тогтворгүйтэх судасны лугшилт олшрох
 4. Тэнцвэрийн сорил тод бус
 5. Дагзны булчингийн хөшингө илрэх
- /149./ Гематогенный остеомиелит эмнэл зүйн явцаар
1. Хурц
 2. Архаг
 3. Анхдагч архаг
 4. Халдварын дараа
 5. Хожуу
- /150./ Хэвлийн гэмтэл
1. Гэмтэл нь дотроо цул ба хөндий эрхтэний гэж байдаг
 2. Хэвлийн хөндийн нэвтэрсэн шархтай өвчтөнд яаралтай мэс засал хийнэ.
 3. Хөндийт эрхтэний гэмтлийн үед пневмоперитонеум болно. /хэвлийн хөндийн эрхтэний бүрхэвч хальсанд хий хурна/
 4. Хэвлийн гэмтэлтэй хүнд бодит үзлэг хийх ач холбогдол багатай
 5. Бөөрний аливаа гэмтэлтэй хүнд тохиолдол бүрт мэс засал хийнэ.
- /151./ Ясны хугарлын эвийн эмчилгээний аргыг нэрлэнэ үү.
1. Ясны татлага
 2. Бариа засал
 3. Гөлтгөнөн боолт
 4. Чөмөгний голоор бэхэлж хадах
 5. Шахах сунгах аппарат эмчилгээ
- /152./ Гэмтлийн удаан дарагдлын синдром
1. Булчингийн эдийн ноцтой гэмтэл үүснэ.
 2. Машиндаа дарагдсан хүнийг чөлөөлөхөд циркуляцын дестрессд оруулж болно.
 3. Гиперкалеми болон бөөрний дутагдлаас өвчнийг сэргийлэхийн тулд сэхээн амьдруулахад эмчилгээ хийнэ.
 4. Гиперкалемийг сэдэж авах элемент байхгүй.
 5. Бөөрний дутагдал чухал биш.
- /153./ Түлэнхий өвчний үед даавраар эмчлэх заалт юу вэ?
1. Шокийн үед
 2. Халдвар хордлогын үед
 3. Гломерулонефритээр хүндрэхэд
 4. Курлингийн шархны үед
 5. Курлингийн шархны үед
- /154./ Түлэнхийн шокийн үед клиникийн аль шинж нь зөв вэ?
1. Захын судасны тонус алдагдана.
 2. Төв мэдрэлийн тогтолцоо сааталд орно.
 3. Дасан зохицох чадвар хангалтгүй
 4. Бичил цусан хангамж хангалттай

5. Хүчил шүлтийн тэнцвэр хэвийн.

/155./ Цахилгааны түлэгдэл дулааны түлэгдэлээс ялгаатай нь

1. Түлэнхийн шарх байхгүй
2. Гэмтсэн хэсэг үсэн бүрхэвч хэвээр байна
3. Гэмтсэн хэсэгт үсэн бүрхэвч алга болно.
4. Өвдөлт байхгүй
5. Шарх үхжилттэй

/156./ Дунд чөмөгний хүзүүний хугарлын үед илрэх шинж тэмдгийг нэрлэнэ үү.

1. Өвдөлт
2. Өсгийн наалдах шинж
3. Хөлийн тавхайн гадагш эргэх
4. Доод мөч богиносох
5. Гуя цавь руу дамжиж өвдөх

/157./ Аман хүзүүний хугарлын онцлогыг нэрлэнэ үү?

1. Хугарлын шугам нурууны артерийн суваг дайрах нь элбэг
2. Ар, хажуу нуман хэсэг илүү гэмтэнэ
3. Хөндий том, бат бөх холбоостой учир нугас гэмтэх нь ховор
4. Нугас элбэг
5. Нумын хэсэг ихэнхдээ гэмтэхгүй

/158./ Шилжүүлэн нөхөж буй арьсыг тор үүсгэх зорилго

1. Талбайг томруулах
2. Арьсны дутмагшилтай шарханд шилжүүлж буй арьсыг бүрэн хүргэх
3. Нөхөж буй арьсны дор цус хурахаас хамгаалах,
4. Эдгэрэлтийг сайжруулна.
5. Арьсны тэжээл авалтыг сайжруулах

/159./ Богтны мэдрэл бугалаганы хэсэгт бүрэн тасарсан бол ямар шинж тэмдэг илрэх вэ?

1. Сарвууны жижиг булчингийн үйл ажиллагаа хомсдоно.
2. 3, 4-р хуруунуудын угын шивнүүрээр тэнийсэн.
3. 3, 4, 5-р хуруунуудын төгсгөлийн болон дунд шивнүүрүүдээр нугалсан
4. Арьс хуурай, хөлсний ялгаралт өөрчлөгдсөн, арьс хүйтэн, хөхөрсөн.
5. Thenar, Hypothenar булчин хөнгөн хатингаршина.

/160./ Хугарсан ясыг эвлүүлж ялтас тавьж бэхлэхэд эсрэг заалт аль нь вэ?

1. Яс сийрэгжсэн
2. Хугархайн түвшинд зөөлөн эд их хэмжээгээр няцарч гэмтсэн ил хугарал
3. Идээлж, халдварлагдсан хугарлууд
4. Хугарлын түвшинд зузаан сорви, цоорхойтой
5. Ясны идээт үрэвсэлтэй

/161./ Холголт үүсэхээс яаж сэргийлэх вэ?

1. Өвчтөнг хатуу тольгор орон дээр хэвтүүлэх
2. Холголт үүсч болох хэсгүүдэд дугуйвч хэрэглэх
3. Арьсыг камфорын спиртээр арчих
4. Өвчтөнг ойр ойрхон байрлалыг орон дээр нь сольж байх
5. Хоолны үүрмэгийг цэвэрлэж байх

/162./ Ясны эвийн эмчилгээнд хуурамч үе үүсэх шалтгаан

1. бэхэлгээг олон дахин солих
2. хугархайг бүрэн эвлүүлээгүй
3. хугархайн хооронд зөөлөн эд хавчуулагдсан
4. витамин хооллолтын дутмагшид
5. Ачаалал эрт өгөх

/163./ Хөлдөлтийн I, II үед ямар өөрчлөлт хэсэг газарт илрэх вэ?

1. Арьс хөхрөх
2. Арьсан дээр цэврүү үүсэх
3. Зөөлөн эд үхжих
4. Арьс цайрах
5. Арьс үхжих

/164./ Настангуудийн түлэгдлийн онцлог юу вэ?

1. Зүрхний инфаркт хүчтэй өвдөлт өгнө.
2. Суурь өвчин нь хүндрэнэ
3. Өндөр халуурна.
4. Уушгины хатгалгаа, үжлээр илүү хүндэрнэ.
5. Судасны бөгрөрөл ховор тохиолддог

/165./ Шөрмөсний дутмагшлыг нөхөхөд хэрэглэдэг шөрмөс

1. Palmaris longus
2. Extensor digitorum longus of the le
3. Plexor digitorum superficialis
4. Pedis dorsalis
5. Latismus dorsi

/166./ Эрт Некрозектомия хийх хамгийн тохиромжтой хугацаа

1. Түлэгдсэний дараа
2. Түлэгдсэнээс хойш 9 өдрөөс
3. Түлэгдсэнээс хойш 5-7 өдөр
4. Түлэгдсэнээс хойш 2-3 өдөр
5. Түлэгдсэний дараахан

/167./ Түнхний асептический остеонекроз

1. Хүүхдийн түнхний асептик остеоэнекроз нь юунаас ч шалтгаалахгүй өөрөө үүсдэг
2. Энэ нь кортикоид гормон удаан хэрэглэх, тетаболийн гаралтай зарим өвчнөөс эсвэл насанд хүрсэн хүмүүст архидалтаас шалтгаалж үүсдэг
3. Хүүхдийн хувьд дунд чөмөгний толгой дахин бүрэлдтэл эвийн эмчилгээ хийж болно
4. Насанд хүрсэн хүний рентген зурагнаас дунд чөмөгний толгой доош унаж, өндөгний голын шар шиг харагдана
5. Дунд чөмөгний толгойг өрөмдөх нь толгойн асептический некрозыг эмчлэх арга биш

/168./ Тархины доргилтын үед авах арга хэмжээнүүдийг заана уу?

1. Хөдөлгөөнгүй тайван хэвтүүлж толгойд хүйтэн жин тавих
2. Тархины хаван хөөх
3. Судасны ханын нэвчимхий чанарыг багасгах
4. Гипотонийн эсрэг
5. Тархины няцрал, цус харвалт цус хуралтыг үгүйсгэсэний дараа бариа засал хийх

/169./ Цээжний гэмтлийн талаар

1. Цээжний ил гэмтлийн тохиолдол бүрд мэс засах хийхгүй
2. I болон II хавирга, өвчүү хугарахад аортограмм шинжилгээ хийх шаардлагатай
3. Цээжний хөндийд тавьсан гуурсаар 1500-2000 мл цус гарах, 4 цаг тутамд 1500-2000 мл цус хий гарч байвал тораектомия хагалгаа хийнэ
4. Олон хавирга хугарсан тохиолдолд мэс заслын эмчилгээ хийх ёстой
5. Цээжний хөндийд нэвтэрсэн тохиолдол бүрд мэс заслын эмчилгээ хийнэ

/170./ Гөлтгөнөн боолтын сайн талыг нэрлэнэ үү.

1. Амархан хэвшиж хатдаг
2. Хаана хэзээ ч хэрэглэж болдог
3. Үений хөдөлгөөн хязгаарлагддаг
4. Үений хөдөлгөөн хязгаарлагдаж хугарлыг бэхэлнэ
5. Тээвэрлэхэд тохиромжтой

/171./ Ясны архаг үрэвслийн шинжийг нэрлэнэ үү?

1. Үе үе дахилт өгнө
2. Архаг идээт хордлогын шинж
3. Арьсан дээр идээт нүхтэй сорвитой
4. Арьсны уян чанар алдагдана
5. Хэсэг газрын хэлбэр өөрчлөгдөнө

/172./ Хөдөө орон нутагт бага насны түлэнхийн шоктой хүүхдэд шингэн сэлбэх энгийн найдвартай арга аль нь вэ?

1. Захын хураагуурт хатгах
2. Төвийн хураагуурт гуурс суулгах

3. Гүрээний хураагуурт хатгах
 4. Ясны хэмэнд хатгах
 5. Толгойн хураагуурт хатгах
- /173./ Түлэнхийн шокийн үеийн анхдагч цус багадалтанд аль нь хүрэх вэ?
1. Цусны эсүүд агрегаци болсноос
 2. Цусанд гемолиз явагдсанаас
 3. Эритроцит шууд үрэгдсэнээс
 4. Хялгасан судсанд цус алдалт болсноос
 5. Цус шингэрснээс
- /174./ Дунд чөмөгний толгой, үений тогооны харьцаагаар дисплазыг зэрэглэх
1. Хагас мултрал
 2. Мултрал
 3. Дутуу хөгжил
 4. Хагас дутуу хөгжил
 5. Мултралын өмнөх
- /175./ Түлэнхийн хордлогын үеийн тэргүүлэх шинж тэмдэг нь юу вэ?
1. Цусан дахь уургийн хэмжээ багасах болон өөрчлөлтөнд орох
 2. Хордлого илрэх
 3. Цус багадах
 4. Бактериемия
 5. Шарх идээлэх
- /176./ Эгэмийн хугарлын үед ямар хүндрэл гарч болох вэ?
1. Эгэм-өвчүүний үе гэмтэх
 2. Эгэм-далны их шонтонгийн үе гэмтэх
 3. 1-р хавирга хугарах
 4. Пневмогемоторакс.
 5. Мөрний мэдрэлийн сүлжээ гэмтэх
- /177./ Шахаж сунгах аппарат эмчилгээний давуу талыг нэрлэнэ үү.
1. Хугарлын голомтонд хөнөөл учруулдаггүй
 2. Хугарлын голомтоос зайдуу
 3. Үений хөдөлгөөн хязгаарлагддаггүй
 4. Хугарлаар чөлөөтэй хөдөлгөж засах боломжтой
 5. Өвчтөн идэвхтэй байдалд эрт орно.
- /178./ Ясны татлага хийх цэгүүдийг нэрлэнэ үү?
1. Дунд чөмөгний доод булуунаас
 2. Дунд чөмөгний их эргүүлгээс
 3. Шаант чөмөгний урд бурзангаас
 4. Өсгий яснаас
 5. Залаа яснаас
- /179./ Чөмөгний гадна ясыг хадаж болохгүй заалт
1. Яс сийрэгжсэн
 2. Ил хугарлын түвшинд
 3. Хугарлаар халдвар авсан
 4. Цоорхой, остеомиэлит, арьсны их сорви
 5. Сорви арьсанд ихээр үүссэн
- /180./ Түлэнхийн тавыг нэвтэрч үйлчлэх тос
1. Панкипсин
 2. Фламмазин
 3. Сильваден
 4. Сульфмилон
 5. Мево
- /181./ Түлэгдлийн зэргийг зөв тогтооно уу
1. 1-р зэрэг өвдөлт ихтэй
 2. IIIA цэврүүний ёроол ягаан
 3. IIIB цэврүүний ёроол цайвар

4. II Цэврүү нь том, шар үс өвдөлтгүй авагдана.
 5. IY Өвдөлт ихтэй
- /182./ Эрт илрэх гепатит ямар шалтгаантай вэ?
1. Хоол, тэжээлийн тохиромжгүй
 2. Элэгний дистрофия өөрчлөлт
 3. Шокын эсрэг эмчилгээ тохироогүйгээс
 4. Гемолиз үргэлжилж байгаа
 5. Түлэнхийн шарх гүнзгий их хэмжээтэйгээс
- /183./ Аарцаг ясны хугарлын үед гарах шинж тэмдгийг нэрлэнэ үү.
1. Бүсэлхийн орчмоор өвдөнө.
 2. Ларрейгийн шинж
 3. Гэмтсэн хэсэгт хөхөрч хавдах
 4. Вернеллийн шинж
 5. Доод мөчдийн саа саажилт
- /184./ Тархины хөнгөн зэргийн бяцралын үед бодит үзлэгээр илрэх шинжүүдийг заана уу?
1. Нүдний алимны чичирхийлэх хөдөлгөөн илрэх
 2. Хүүхэн хараа ижил байх
 3. Шөрмөсний рефлекс хоёр талдаа ижил бус болох зарим эмгэг рефлексүүд үүсэх
 4. Тэнцвэрийн сорил ажиглагдана
 5. Биеийн халуун ихсэх
- /185./ Бөөрний гэмтлийг яаж ангилдаг вэ?
1. Бөөрний эд бэртэж, няцрах
 2. Урагдаж, хагарах
 3. Урагдаж, цус хурах
 4. Шээсний хураагуур хагарах
 5. Судасны багц гэмтэх
- /186./ Хүүхдэд цусаар түгсэн цочмог ясны идээт үрэвслийг ямар эмгэгтэй ялган оношлох вэ?
1. Целюлит
 2. Флегмона
 3. Битүү гэмтэл
 4. Ясны хорт хавдар
 5. Эмгэг хугарал
- /187./ Ясны архаг үрэвслийн рентген шинжийг дурьдана уу.
1. Яс зузаарч хатуурна /остеоскелероз/
 2. Яс ууссан юм шиг харагдана.
 3. Склероз.
 4. Ясны бүтцэд өөрчлөлт гарахгүй.
 5. Ясанд хөндий үүснэ.
- /188./ Түлэнхий өвчтэй хүнд зондоор шингэн хоол өгөхөд хэдэн хувь нь биед шингэх вэ?
1. 20%
 2. 40%
 3. 60%
 4. 70%
 5. 80%
- /189./ Түлэнхийн шоконд ялгарах даавруудын аль нь зөв вэ?
1. Кортикостероидууд буурна
 2. Антидиуретик гормон ихэснэ
 3. Альдостерон буурна.
 4. Бэлгийн гормон ихэснэ.
 5. Бамбай булчирхайн даавар буурна
- /190./ Мөч тасрах механикаар ангилах
1. Татагдаж
 2. Зүсэгдэж
 3. Дарагдаж

4. Хөрөөдөгдөж

5. Цавчигдаж

/191./ Түлэнхийн хордлогын үед плазмын уургийн ерөнхий түвшин

1. Бага зэрэг буурна

2. Бага зэрэг ихсэнэ

3. Хэвийн хэмжээнд ойрхон байна

4. Ихээхэн буурна

5. Ихсэнэ.

/192./ Эгэмийн хугарлын үед ямар хүндрэл гарч болох вэ?

1. Эгэм-өвчүүний үе гэмтэх

2. Эгэм-далны их шонтонгийн үе гэмтэх

3. 1-р хавирга хугарах

4. Пневмогемоторакс.

5. Мөрний мэдрэлийн сүлжээ гэмтэх

/193./ Нугалмын эвэрхийний тухай зөв хариуг нэрлэнэ үү

1. СТ зурган дээр эвэрхий харагдаж байвал дискэктомия хийх хэрэгтэй.

2. Радикулитгүй өвчтөнд эвэрхий илэрч болно

3. L5-S1-ийн эвэрхий L5 ёзоорыг дардаг.

4. L4-L5-ийн төвийн эвэрхий L4 ёзоорыг дардаг

5. L4 ёзоорын өвдөлт нь гуя болон хөлний гадна хажуугаар уруудаж мэдрэгдэнэ.

/194./ Ясны татлага хийх заалт

1. дунд чөмөгний дээд хэсгийн хугарал

2. шилбэний ясны бүх төрлийн хугарал

3. аарцаг ясны цагираг тасарсан хугарал

4. шуу богтос ясны хугарал

5. эгэмний ясны хугарал

/195./ Голомтоос зайдуу ясыг хадах (external fixation) заалт

1. Чөмөгт ясны олон сэлтрэлтэй хугарал

2. Чөмөгт ясны олон сэлтрэлтэй эпиметафизын хугарал

3. Зөөлөн эдийн няцрал гэмтэл ихтэй чөмөгт ясны хугарал

4. Идээт халдвар авсан

5. Ил хугарал

/196./ Аарцаг ясны хугарлын үед гарах шинж тэмдгийг нэрлэнэ үү.

1. Бүсэлхийн орчмоор өвдөнө

2. Ларрейгийн шинж

3. Гэмтсэн хэсэгт хөхөрч хавдах

4. Вернеллийн шинж

5. Доод мөчдийн саа саажилт

/197./ Түлэгдэлтийн талбайг аль нь зөв тодорхойлох вэ?

1. Хүзүү толгой 9%

2. Нэг гар 9%

3. Нэг хөл 18%

4. Их бие 30%

5. Хярзан 2%

/198./ ОО дээш температурт осгоход нөлөөлөх хүчин зүйл

1. Салхитай цаг агаар

2. Чийглэг

3. Барьсан хувцастай

4. Судасны архаг өвчлөл, гэмтэлтэй

5. Эцэж ядарсан, шархдсан

/199./ Өвдөгний үенд дурангаар ямар хагалгаа хийж болох вэ?

1. Менискийг оёх, хэсэгчлэн тайрах

2. Хэрээс хэлбэрийн холбоосыг сэргээх

3. Үений доторхи өөрчлөгдсөн нуглаас, хуниасыг тайрах

4. Синовиял бүрхэвчийг авах

5. Гадна биетийг авах

/200./ Тархины хатуу хальсны дээрхи цусан хурааны үед гарах эмнэл зүйн шинж тэмдгийг заана уу?

1. Толгой тэлж өвдөх, бөөлжих, судасны цохилт удаашрах даралт ихсэх
2. Ухаан даамжран балартах хөдөлгөөн ихсэх шинжүүд гүнзгийрнэ.
3. Тал саажилт үүсэх
4. Цусан хураа үүсч буй талд хүүхэн хараа өргөсөх, нүд гадагшаа эргэх, зовхи буух эвэрлэгийн рефлексгүй болох , булчингийн тонус сулрах, амьсгал зүрх судасны дутагдал илрэх
5. Голомтын эсрэг талд гар хөлийн рефлекс ихсэх, эмгэг рефлекс үүсэх

Сорилын зөв хариулт -/1-200/

1-Е, 2-В, 3-С, 4-Е, 5-А, 6-С, 7-В, 8-А, 9-Д, 10-Е, 11-С, 12-Е, 13-Д, 14-Д, 15-С, 16-С, 17-А, 18-В, 19-Е, 20-С, 21-В, 22-Д, 23-А, 24-Д, 25-В, 26-В, 27-С, 28-Е, 29-С, 30-С, 31-Д, 32-В, 33-С, 34-В, 35-А, 36-В, 37-С, 38-Е, 39-С, 40-В, 41-А, 42-В, 43-Д, 44-С, 45-С, 46-Д, 47-В, 48-Е, 49-В, 50-В, 51-А, 52-В, 53-Д, 54-Е, 55-В, 56-С, 57-С, 58-С, 59-Д, 60-Е, 61-С, 62-А, 63-Д, 64-А, 65-В, 66-В, 67-С, 68-Д, 69-А, 70-А, 71-С, 72-В, 73-В, 74-А, 75-Д, 76-С, 77-Е, 78-Д, 79-Д, 80-А, 81-А, 82-Е, 83-С, 84-Е, 85-В, 86-В, 87-А, 88-Е, 89-С, 90-В, 91-А, 92-Д, 93-Д, 94-А, 95-А, 96-С, 97-Е, 98-Д, 99-Е, 100-А, 101-С, 102-Д, 103-А, 104-Е, 105-Е, 106-А, 107-Е, 108-А, 109-Е, 110-А, 111-А, 112-А, 113-А, 114-Е, 115-Е, 116-С, 117-Д, 118-Е, 119-А, 120-С, 121-Е, 122-Е, 123-Д, 124-А, 125-А, 126-А, 127-А, 128-Е, 129-С, 130-А, 131-Е, 132-Д, 133-А, 134-А, 135-Е, 136-А, 137-С, 138-Д, 139-Е, 140-С, 141-А, 142-Е, 143-Д, 144-А, 145-А, 146-А, 147-А, 148-Е, 149-А, 150-А, 151-А, 152-А, 153-А, 154-А, 155-С, 156-Е, 157-А, 158-А, 159-Е, 160-Е, 161-Е, 162-Е, 163-С, 164-С, 165-А, 166-Д, 167-Е, 168-Е, 169-А, 170-Е, 171-Е, 172-Д, 173-А, 174-А, 175-А, 176-Е, 177-Е, 178-Е, 179-Е, 180-Д, 181-А, 182-Д, 183-С, 184-Е, 185-Е, 186-А, 187-А, 188-Д, 189-А, 190-А, 191-Д, 192-Е, 193-А, 194-А, 195-Е, 196-С, 197-А, 198-Е, 199-Е, 200-Е,


Тохиолдол 1

Өвчтөн Р 35 настай, эрэгтэй шороо нурж нуруугаараа бөгтийж дарагдсан гэсэн дуудлаганд эмч очив.

Үзэхэд: царай цонхигор цайвар, асуултанд цөөн үгээр зөв хариулна. Пульс 1 минутанд 108 АД 100/60 мм м.у.б. Зүрхний авиа түргэссэн. Уушиг хэвийн амьсгалтай, хэвлий зөөлөн, давсаг дүүрэн шээстэй. Байрлал албадмал, зөвхөн бусдын дэмжлэгтэйгээр хөдөлгөөн хийнэ.

Хэсэг газарт: Бүсэлхий орчмын нурууны хэсэгт хавдаж хөхөрсөн, гадагш овойсон, барьж тэмтрэхэд өвдөлт ихэснэ. Өвдөлт бүсэлхий ороосон ба тухайн хэсэг газарт илүү их эмзэглэлтэй байна.

Мэдрэлийн үзлэгт: 2 хөлөө хөдөлгөж чадахгүй хүйснээс доош өнгөц ба гүний мэдрэхүй алдагдсан, өвдөлт ба халуун хүйтний мэдрэхүй арилсан, улны рефлекс үүсэхгүй. Өтгөн шингэнээ гаргаж чадахгүй.



Нуруу нугаламын үед MRI болон Рентгенд гарах өөрчлөлт

1. Нурууны аль хэсгийг гэмтээсэн бэ?

1. Сээрний доод түвшинд
2. Сээр бүсэлхийн уулзвар хэсэгт
3. Аль ч түвшинг хамарч болно
4. Бүсэлхийн хэсэгт
5. Хүзүү сээрний уулзварт.

2. Үзүүлэх анхны тусламжийг сонгоно уу?

1. Хөдөлгөөн хязгаарлаж банзтай орон дээр дээш харуулан хэвтүүлнэ. Давсганд шээлгүүр тавина.
2. Өвчин намдаах эмүүд хэрэглэж, шокоос гарах дусал шингэн хийнэ.
3. Хугарсан нурууны орчим новойканы хориг хийнэ
4. Хагас суугаа байрлалд хөдөлгөөнгүй хэвтүүлнэ
5. Өвчин намдаах эм хэрэглэж мэлхий байрлалд хэвтүүлнэ

3. Нэн түрүүнд хийгдэх шинжилгээг сонгоно уу?

1. Нугасны ус авч дарагдлын шинж тэмдгийг үзнэ
2. Хоёр тусгалаар рентген зураг авна
3. MRI
4. КТГ
5. ЭХО

4. Эмчилгээний үндсэн зарчим юу байх вэ?

1. Гильсоны гогцоот татлага хийж эмийн болон физик эмчилгээ хийнэ
2. Эвийн ба эмийн мэс засал эмчилгээ хавсруулан хийнэ
3. Шанцын чиг тавьж Халогийн аппаратаар бэхэлгээ хийнэ
4. Нугасны дарагдлыг чөлөөлж хугарал мултралыг засч бэхэлнэ
5. Чамархайнаас ясны татлага хийж эвийн аргаар хугарал мултралыг оруулна.

5. Гарч болох хүндрэлүүдийг нэрлэнэ үү?

1. Нуруу нугасны шоконд орох
2. Өгзөг өсгийнд холголт үүсэх
3. Бөөрний замын халдвар авч хүндрэх
4. Тархи хавагнаж комд орох
5. Мөчдөд атрофи үүсч тэжээл алдагдана

№	1	2	3	4	5
Хариу	D	A	B	C	A

Тохиолдол 2

Өвчтөн С. 25 настай эрэгтэй . Барилдаж байгаад баруун мөрөөрөө дарж унасан. Зүүн гараараа баруун гараа түшиж өргөсөн албадмал байрлалтай. Баруун мөрний орчим өвчтэй хөдөлгөж чадахгүй.

Үзэхэд: Баруун мөрний хэлбэр алдагдсан, хавдсан идэвхитэй хөдөлгөөн хязгаарлагдсан. Урагш дээш овойсон, ар талд нь хоосон тогооны шинж илэрсэн. Хэсэг газар тэмтрэхэд өвчтэй. Сарвууны атгах ба тэнийлгэх үйл ажиллагаа хэвийн байв.

1. Анатомийн байрлалаар ямар хэсгүүд гэмтсэн байж болох вэ?

1. Акромион сэртэнгийн хугарал
2. Мөрний мултрал ба бугалганы толгойны хугарал
3. Бугалганы анатомийн хүзүүгээр хугарсан
4. Мөрний мултрал үүссэн
5. 2 толгойт булчингийн суналт

2. Онош тодруулах үйлдлүүдийг нэрлэнэ үү?

1. Бугалганы 2 талаас шахаж үзнэ
2. 2 чиглэлээр рентген зураг авч үзнэ
3. КТГ
4. Артроскопи хийж оношлоно
5. Артрограмм мөрний үенд хийнэ

3. Эмнэл зүйд анхдагч үзлэгээр илрэх шинж тэмдгүүдийг дурьдана уу?

1. Өвдөх
2. Хавдах ба хэлбэр дүрсээ алдах
3. Хөдөлгөөн хязгаарлагдах
4. Яс хавирах чимээ мэдрэгдэх
5. Улайх

4. Эмчилгээний арга техникийг сонгоно уу?

1. Мэс засал хийж мултрал оруулна
2. Унтуулгатайгаар Кохерын аргаар оруулна
3. Мултралыг оруулж 8 тоо хэлбэртэй боолт 14 хоног хийх
4. Мултралыг оруулж Дезо маягийн боолт 14 хоног хийх
5. Массаж, шарлага, шавар эмчилгээ хийхэд хангалттай

№	1	2	3	4
Хариу	В	А	А	С

Тохиолдол 3

45 настай эрэгтэй мориноос унаж гэмтсэн.

Үзэхэд: баруун шууны урьд хэсгээр хавантай, зүүн гуя хавдсан хөхөрсөн дунд хэсгээр гадагш овойсон. Ясны хавиралдах чимээтэй хугарлаар эмгэг хөдөлгөөнтэй.

Рентгенд зүүн дунд чөмөг, чөмөгт хэсгээр ташуу хугарч зөрсөн. Баруун шууны хугарамтгай хэсгээр хөндлөн хугарсан зөрөөгүй. Эмч үзэж, дунд чөмөгнд ясны татлага шуунд гөлтгөнөн боолт тавихаар болов.

1. Ясны татлага хийхэд хэрэглэх багаж материалыг сонгоно уу?

1. Шөрөг
2. ЦИТО-ийн нум
3. Беллерийн чиг
4. Шөрөг чангалагч түлхүүр
5. Гар буюу цахилгаан дрель

2. Дунд чөмөгний хугарлын үед ясны татлага хийх цэгийн сонгоно уу?

1. Дунд чөмөгний дээд булуу
2. Шаант чөмөгний урд бурзан
3. Дунд чөмөгний чөмөгт хэсэг
4. Дунд чөмөгний доод булууны метафиз
5. Өсгий яс

3. Шууны хугарамтгай хэсгийн хугарлын үед гөлтгөнөн боолтуудыг хаанаас хаана хүртэл хэмжиж тавих вэ?

1. Хурууны үзүүрээс тохойн үе хүртэл
2. Хурууны угийн үенээс мөрний үе хүртэл
3. Бугуйн үенээс атгаалын доод 1/3 хүртэл
4. Хурууны угийн үенээс тохойн үе хүртэл
5. Бугуйн үенээс мөрний үе хүртэл

4. Чөмөгт ясны хугарлын үед илрэх үндсэн шинж тэмдгийг нэрлэнэ үү?

1. Хавантай
2. Эмгэг хөдөлгөөнтэй
3. Ясны хавиралдах чимээтэй
4. Үений тогоо, чөмөгний толгой тусдаа тэмтрэгдэнэ
5. Пүрштэй юм шиг эсэргүүцэлтэй

5. Татлагын ачааны хэмжээ юунаас хамаарах вэ?

1. Хугарснаас хойших хугацаа
2. Нас ба булчингийн хөгжил
3. Биеийн онцлог
4. Хугарлын зөрөөний хэлбэр байрлал
5. Гэмтлийн механизм

№	1	2	3	4	5
Хариу	E	C	D	A	C

Тохиолдол 4

Өвчтөн Ц 75 настай Эрэгтэй хальтарч унаж гэмтсэнээс гишгэж явж чадахгүй. **Үзэхэд:** Зүүн гуя хавантай, хөлийн тавхай гадагш эргэн бага зэрэг богиносолттой, өсгий наалдах шинж илрэнэ. Зүүн талын өгзөг ташаа орчмоор хөхөрсөн эмзэглэлтэй,

Рентгенд: Зүүн талын дунд чөмөгний хүзүү хөндлөн хугарсан, зөрсөн.

Дунд чөмөгний хүзүүний хугаралын үед рентгэн зураг болон эмнэл зүйд гарах өөрчлөлт



1. Урьдчилсан онош тавина уу?

- A. C32B13
- B. C31A3
- C. C42 B21
- D. C31 B3
- E. C22 B13

2. Яаралтай хийх шинжилгээг нэрлэнэ үү?

1. Шээсний ерөнхий шинжилгээ
2. Рентген зураг

3. Цусны ерөнхий шинжилгээ
4. Биохимийн шинжилгээ
5. МРТ

3. Эмчилгээний аргыг нэрлэнэ үү?

1. Бариа засал
2. Ясны татлага
3. Физик эмчилгээ
4. Мэс засал
5. Иллэг массаж

4. Мэс заслын эмчилгээ хийх боломжгүй тохиолдолд ямар эмчилгээ хийх вэ?

1. Бариа засал
2. Сапочик
3. Корсет
4. Коксет
5. Лонгет

5. Дунд чөмөгний хүзүүний хугарлын үед ясны татлага хийх цэгийг нэрлэнэ үү?

1. Өсгий яс
2. Шаантны урд бурзан
3. Шагайн яс
4. Дунд чөмөгний доод булууны метафиз
5. Дунд чөмөгний чөмөгт хэсэг

№	1	2	3	4	5
Хариу	D	A	C	C	C

Тохиолдол 5

Өвчтөн Н 2 настай, эмэгтэй 3 хоногийн өмнө халуун цайнд түлэгдэж гэрээр эмчлэгдэж байгаад замын унаагаар түлэнхийн төвийн хүлээн авахаар ирсэн.

Эмч үзэхэд: цээж хэвлийн урд хэсэг түлэгдэж цэврүүтсэн, шархнаас идээрхэг шүүдэс гарна, нүүр болон хөл гараар хаван ихтэй хэл хуурай, шээс ховордуу гарна, хоол хөхөндөө дургүй байнга уйлагнаж унтаа байдалтай гэсэн зовиуртай.



Түлэнхийн шархны үед гарах эмгэг өөрчлөлт

1.Түлэнхийн шархыг үүсгэж буй шалтгааны ангиллыг нэрлэнэ үү?

1. Химийн түлэгдэл
2. Дулааны түлэгдэл
3. Цахилгааны түлэгдэл
4. Хүчдэлийн түлэгдэл
5. Механик түлэгдэл

2. Түлэнхий өвчний эмгэг жамыг нэрлэнэ үү?

1. Түлэнхийн шок

2. Хурц хордлого
3. Шархны халдвар, хордлого
4. Эдгэрэх үе
5. Үхжлийн үе

3. Түлэнхийн шархны хэмжээг тодорхойлох аргыг нэрлэнэ үү?

1. Метрээр хэмжих арга
2. Алганы дүрэм
3. Цаасан шувууны дүрэм
4. Естын дүрэм
5. Угломерээр хэмжих арга

4. Түлэгдэлтэй өвчтөнийг тээвэрлэх үед гарах хүндрэлийг нэрлэнэ үү?

1. Цус алдалт
2. Өвдөлтийн шок
3. Уналт таталт
4. Хордлого
5. Доргилт

5. Түлэнхийн шархыг эмнэлгийн нөхцөлд боолт хийхэд баримтлах зарчмыг нэрлэнэ үү?

1. Өвчин намдаах эм тариаг тухайн өвчтөний нас биенд тохируулж хийж, тайван байлгах
2. Шархыг бүлээн устай шүршүүр болон марганцтай ваннанд оруулж дэвтээнэ.
3. Шархыг антисептик уусмалаар шавшиж шүршиж угаана
4. Цэврүүг хагалж цэвэрлэнэ
5. Шарханд битүү боолт хийнэ

№	1	2	3	4	5
Хариу	A	B	C	C	E

Тохиолдол 6

Өвчтөн 6 сартай, охин ээж нь хэлэхдээ өгзөгний нуглаас тэнцүү бус, зогсоход баруун хөлөө өргөөд гүйцэд гишгэж чадахгүй байна гэсэн зовиуртай эмчид хандав. Эмч үзээд баруун түнхний үений мултрал байж болзошгүй учраас рентген зураг авахуулах болов.

1. Төрөлхийн түнхний эмгэг үүсэх хүчин зүйлийг нэрлэнэ үү?

1. Эхийн жирэмсэн үеийн хордлого
2. Илүү тээлт
3. Удамшил
4. Хүүхдийг буруу өлгийдөж, тэврэх
5. Жирэмсэн үеийн хоолны дутмаг байдал

2. Төрөлхийн түнхний гажгуудын хэлбэрийг сонгоно уу?

1. Төрөлхийн түнхний мултрал
2. Буруу хөгжил (дисплази)
3. Дутуу хөгжил (гипоплази)
4. Төрөлхийн түнхний хүзүүний хугарал
5. Төрөх үеийн гэмтэл

3. Төрөлхийн түнхний согогтой хүүхдийн түнхний рентген зургийг хэзээ авахад хамгийн тохиромжтой вэ?

1. Төрсний дараа эхний 14 хоног
2. Төрсний дараа 3 сарын дараа
3. Хугацаа онц ач холбогдолгүй
4. Төрснөөс хойш 4-5 сартайд
5. Хүүхдийг 1 настайд нь авах



Аарцаг, түнхний үений эгц урдаас авсан рентген зураг

4. Төрөлхийн түнхний мултралтай хүүхдэд эрт илрэх үндсэн шинжийг нэрлэнэ үү?

1. Өгзөгний нугалаас тэнцүү бус байх
2. Алцайлгах өнцөг хязгаарлагдах
3. Маркс – Ортнерийн шинж мэдрэгдэх
4. Хөл урт богино байх
5. Явахдаа мултралтай талдаа доглох



Төрөлхийн түнхний дутмаг хөгжлийн бодит зураг

5. Төрөлхийн түнхний мултралын өвчний эмчилгээний аргыг нэрлэнэ үү?

1. Зөв өлгийдөх, тэврэх
2. Павлокын дөрөөвч хэрэглэх
3. Шнедрийн нум ашиглан татлага хийх
4. Лоренцын гипс тавих
5. Шавар эмчилгээ, массаж иллэг

6. Доорх зураг дээр хэний шинж илэрч байна вэ?

1. Дюптрений шинж
2. Трендленбургийн шинж
3. Дюшений шинж
4. Маркс – Ортнерийн шинж
5. Ларейгийн шинж

№	1	2	3	4	5	6
Хариу	B	A	E	A	E	D